

“Зээлийн хүүг бууруулах стратеги” хэлэлцүүлгийн хураангуй



“ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ СТРАТЕГИ”

| 2018 ОНЫ 3 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР
УЛААНБААТАР ХОТ



АГУУЛГА

Нээлтийн үг - Н.Баяртсайхан, Монголбанкны Ерөнхийлөгч.....	4
Илтгэл - Д.Ган-Очир, Монголбанкны Судалгаа, статистикийн газрын захирал.....	6
Хэлэлцүүлэг - Зээлийн хүүг бууруулах стратеги.....	8



Та бүхний энэ өдрийн амар амгаланг эрье.

Монголбанкны урилгыг хүлээн авч хүрэлцэн ирсэн Та бүхэнд талархал илэрхийлье!

Монголбанкнаас эдийн засгийн бодлогын асуудлыг хөндсөн чуулган, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулж байна. Энэ оны нэгдүгээр сард “Эдийн засгийн бодлогын анхдугаар чуулган”-ыг Эрдэнэт хотноо “Эдийн засгийн чиг хандлага, сорилтууд” сэдвийн дор амжилттай зохион байгуулж, манай орны эдийн засгийн энэ жилийн өнгийг тодорхойлсон билээ. Мөн хоёрдугаар сард Монгол улсын эдийн засгийн тогтвортой хөгжил, өсөлтийн бодлогын жор болох учиртай “Улаанбаатарын зөвшилцөл”-ийг санал болгох хэлэлцүүлгийг зохион байгуулсан билээ. Үргэлжлүүлээд “Эдийн засгийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага - 2018” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг Монгол улсын их сургууль, Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран гуравдугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, Монголбанкин дээр хийгдсэн зарим судалгааны үр дүнг танилцуулсан юм.

Өнөөдөр “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн баримт бичгийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий, Монголбанкнаас байгуулсан ажлын хэсгийн тайланг хэлэлцүүлж, Та бүхний саналыг авахыг зорьж байна.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын 2017 оны 70 дугаар тогтоолын 3 дахь хэсгийн 4-т: “Зээлийн хүү бууруулах стратеги боловсруулах” үүргийг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд даалгасан билээ. Тус стратегийн баримт бичгийн төслийг боловсруулах ажлын хэсгийг олон талын төлөөллийг оролцуулан өнгөрсөн оны аравдугаар сард миний бие тушаалаар байгуулсан бөгөөд энэхүү ажлын хэсгийн тайлан бэлэн болсны дагуу Та бүхэнд танилцуулах зорилгоор энэ арга хэмжээг зохион байгуулж байна.

Манай оронд сүүлийн жилүүдэд зээлийн хүү өндөр байгаа асуудал бодлогын түвшинд яригдаж байсан ч дорвитой буурахгүй, харин ч өндөр түвшинд байсаар ирлээ. Өнгөрсөн хугацаанд зээлийн хүүг бууруулах чиглэлээр тусгай хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлсэн хэдий ч дорвитой үр дүн гарсангүй өдийг хүрлээ. Тухайлбал, “Зээлийн хүү буурах зах зээлийн орчинг бүрдүүлэх хөтөлбөр” 2011 онд, “Зээлийн хүү буурах зах зээлийн орчинг бүрдүүлэхэд чиглэсэн 2014-2016 онд хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийг 2014 онд Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны хамтарсан тушаалаар батлан хэрэгжүүлсэн боловч хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, харилцан нийцгүй, эдийн засгийн бодлого нь нийт нөлөөг сулруулж ирсний дээр гадаад секторын эмзэг байдал өндөртэй манай орны эдийн засаг ээлж дараалсан хүчтэй гадаад цочролтой нүүр тулж байсан нь зээлийн хүү буурах боломжийг хязгаарлаж ирлээ.



Н.Баяртсайхан
Монголбанкны Ерөнхийлөгч

“Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийг зах зээлийн зарчмын хүрээнд боловсруулах учиртай.

Зээлийн хүүг бууруулах чиглэлээр боловсруулсан хөтөлбөр, Монголбанкнаас баримталж ирсэн бодлого, зарчим нь зээлийн хүүний түвшинг захиргаадалтын аргаар бус, харин эдийн засаг, санхүү, хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх замаар бууруулах нь зохистой гэж үзэж ирсэн билээ. Захиргаадалтын аргаар хүүг бууруулах нь зах зээл, эдийн засагт нэмэлт гажуудлыг бий болгох эрсдэлтэй тул тогтвортой хэрэгжих боломжгүй юм. Ялангуяа, макро эдийн засаг, санхүүгийн зах зээлийн тогтвортой суурь орчин бүрэлдээгүй өнөө үед зээлийн хүүг захиргаадалтын аргаар бууруулах нь санхүүгийн эс зуучлал, хөрөнгийн зугатаалтыг бий болгож, санхүү, эдийн засгийн хүндрэл рүү ч хөтлөх эрсдэлтэй юм.

Иймд “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн төслийг ч зах зээлийн зарчмын хүрээнд боловсруулж, амжилттай хэрэгжүүлснээр зээлийн хүү буурах макро орчин бүрэлдэж, бодлогын хүүний шилжих суваг эрчимжиж, арилжааны банкны эрсдэл даах чадвар, үр ашиг, засаглал сайжирч, зээлийн хүүний түвшин дорвитой буурах боломж бүрэлдэнэ гэж үзэж байна.

Энэхүү стратегийг 2018 оноос хэрэгжүүлж эхлэх нь цаг хугацааны хувьд зохистой үе болов уу. Учир нь манай орны банкны салбарт активын чанарын үнэлгээ хийгдэж, түүнд суурилан банкны эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээг шат дараатай авч байгаагийн үр дүнд бүрэлдэн бий болж буй эрүүл, хүчирхэг банкны салбар нь зээлийн хүүг бууруулахад чиглэсэн бодлогын арга хэмжээний үр дүн нэмэгдэхэд эерэгээр нөлөөлөх нь гарцаагүй юм. Түүнчлэн эдийн засаг ч сэргэж, цаашид тогтвортой өсөх хүлээлт байна.

Эцэст нь онцлон хэлэхэд, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоо нь энэ стратегийг амжилттай хэрэгжүүлэх, зээлийн хүүг бууруулахад туйлын чухал юм. Ялангуяа, энэхүү дунд хугацааны стратеги нь улс төрийн орчноос үл хамааран манай орны эдийн засгийн бодлогод тогтвортой хадгалагдан хэрэгжиж хэмээнэ үр дүнд хүрэх учиртай.

Эрхэм хүндэт зочин, төлөөлөгч Та бүхнээс “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн төслийг боловсронгуй болгоход оюун ухаанаа чилээн, хувь нэмрээ оруулахыг хүсч байна.

Анхаарал тавьсан Та бүхэнд баярлалаа.

ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ СТРАТЕГИ

Банкны салбарын зээлийн хүү 2000 оноос 2012 он хүртэлх хугацаанд тогтвортой буурч байсан бол сүүлийн 6 жилд өсөх хандлагатай буюу дунджаар жилийн 20 орчим хувьтай байна. Зээлийн хүүний энэ түвшинг бага орлоготой орнуудтай харьцуулахад харьцангуй бага түвшинд байгаа боловч Монгол улсын орлогын ангилал болох дундаас доогуур орлоготой орнуудын дундажтай харьцуулахад 5 нэгж хувиар, Зүүн ази, Номхон Далайн орнуудын дундажтай харьцуулахад 10 гаруй нэгж хувиар өндөр байна. Манай эдийн засагт зээлийн хүү нь хөрөнгө оруулалт, бизнес эрхлэлтийг дэмжих түвшин хүртэл буурахгүй байгаа талаар сүүлийн 20 жилийн турш байнга ярьж, холбогдох бодлогын баримт бичиг боловсруулагдан хэрэгжсэн хэдий ч зээлийн хүү өндөр хэвээр байна. Иймээс зээлийн хүүг цаашид хэрхэн бууруулах арга замыг эрэлхийлэх, бодлогын хүрээнд аль стратегийн хүрээнд ямар арга хэмжээ авах шаардлагатай байгааг тодорхойлох нь чухал юм.

Иймд зээлийн хүү буурахад шаардлагатай эдийн засаг, санхүү болон эрх зүйн суурь орчны талаар үндэсний нэгдсэн ойлголцлыг бий болгож, бодлогын харилцан уялдааг хангахын тулд энэхүү 2018-2023 оны стратеги, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулав. Манай ажлын хэсгийн зүгээс зээлийн хүүг бууруулах стратегийн алсын хараа болон эрхэм зорилгыг дараах байдлаар тодорхойлсон.

Алсын хараа

“Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023” нь бизнес эрхлэх санхүүгийн таатай орчинг бүрдүүлэх, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгох алсын зорилготой.

Эрхэм зорилго

Энэхүү стратегийн эрхэм зорилго нь зээлийн хүү буурах макро эдийн засгийн орчинг бүрдүүлэх, бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх (бодлогын хүүний шилжих сувгийг хүчтэй болгох), банкуудын эрсдэл даах чадвар, үр ашиг болон засаглалыг сайжруулахад чиглэсэн үр дүнтэй арга хэмжээг авах замаар зээлийн хүүг бууруулахад оршино.

Стратегийн зорилтууд нь зээлийн хүү буурах макро орчинг бүрдүүлэх, мөнгөний бодлогын хүүний шилжих нөлөөг нэмэгдүүлэх, банкны салбарын эрсдэл даах, үр ашиг болон засаглалыг сайжруулахад шаардлагатай эрх зүй, удирдлага, журам заавар, үйл ажиллагааны үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн.



Д.Ган-Очир

Судалгаа, статистикийн газрын захирал
Монголбанк

...бизнес эрхлэх
санхүүгийн
таатай орчинг
бүрдүүлэх,
санхүүгийн
хүртээмжийг
нэмэгдүүлэх,
эдийн засгийн
тогтвортой
хөгжлийг бий
болгох алсын
зорилготой...

Зээлийн хүүг бууруулахтай холбогдуулж 11 чиглэл бүхий стратегийн зорилтыг дэвшүүлж байна. Үүнд:

Зорилт 1. Инфляцийг тогтвортой, нам түвшинд байлгах- инфляцийн зорилтот түвшинг хангах.

Зорилт 2. Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, улсын секторын гадаад өрийн тогтвортой байдлыг хангах.

Зорилт 3. Төсвийн сахилга батыг хангах, макро бодлогын уялдааг сайжруулах.

Зорилт 4. Эдийн засгийг төрөлжүүлэх, дотоод хуримтлалыг нэмэгдүүлэх.

Зорилт 5. Бодлогын хүүний коридорыг ашиглан хүүний сувгийн нөлөөг сайжруулах.

Зорилт 6. Санхүүгийн долларжилтыг бууруулах.

Зорилт 7. Хүчтэй санхүүгийн системтэй болох, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг эрчимжүүлэх.

Зорилт 8. Зээлийн мэдээллийн сан, зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх.

Зорилт 9. Зээлийн эрсдэлийг бууруулах, энэ чиглэлд эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох.

Зорилт 10. Банкуудын үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх.

Зорилт 11. Төрийн болон санхүүгийн байгууллагуудын засаглалыг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах

Ажлын хэсгийн зарим гишүүд



Б.Баярдаваа

Мөнгөний бодлогын газрын захирал
Монголбанк

Д.Ган-Очир

Судалгаа, статистикийн газрын захирал
Монголбанк

Г.Бумчимэг

Гүйцэтгэх захирал
Монголын эдийн засгийн шинжилгээ, судалгааны төв

С.Дэмбэрэл

Үүсээн байгуулагч
Эдийн засгийн тинк танк клуб



М.Болд

Гүйцэтгэх захирал
Хас Банк

Юуны өмнө төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлдэг Төвбанк зээлийн хүүг бууруулах өөрийн байр суурийг илэрхийлж, санаачлагыг гартаа авч байгаад туйлын талархалтай байна. Цаашид зээлийн хүүг бууруулахтай холбоотой асуудалд Монголбанк манлайллаа хадгалж, олон нийтэд зөв ойлголт өгөх нь маш хэрэгтэй. Стратегид банкны холбооноос хүргүүлсэн зарим чухал саналуудыг орхигдуулсан гэж үзэж байна. Гадаадаас эх үүсвэр оруулж ирсэн тохиолдолд хэрхэн урамшуулах талаар сайн дурдаагүй байна. Зөвхөн банкууд бус компаниуд гадаадаас шууд эх үүсвэр оруулж ирдэг. Энэ эх үүсвэр дээр хүүний татварыг бууруулах боломжтой юм. Нөгөө талаас төгрөгийг доллар руу хөрвүүлэхэд шимтгэл авах тухай санаа байна. Энэ нь эсрэг нөлөөтэй байж болох юм. Тухайлбал, хөрөнгийн урсгалыг захиргаадгалтын арга хэмжээгээр зохицуулах гэж оролдвол банкны салбар руу орж ирэх хөрөнгийн урсгалыг хаах, албан бус сектор руу дайжих аюулыг бий болгоно. Мөн зах зээлд хэт олон санхүүгийн байгууллагууд байна. Ингэснээр эх үүсвэр дутагдалтай орчинд хэт их өрсөлдөөн бий болгож байна. Иймд санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх босго, шалгуур үзүүлэлтийг өндөр тогтоох тухай асуудлыг авч үзэх хэрэгтэй. Мөн зээл төлүүлэх үйл ажиллагаа их бүрхэг байдаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг түргэн шуурхай болгох ажлыг тэргүүн эгнээнд авч, шийдвэрлэх шаардлагатай байна.

Зээлийн хүүг бууруулах талаар бүгд ярьж байна. Гэтэл зээлийн хүүний талаар нэгдсэн ойлголт, тодорхойлолт алга байна. Иймд Монголбанк, Засгийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, арилжааны банк зэрэг бүх хүрээнд зээлийн хүү гэсэн ойлголтыг нэгдмэл нэр томъёоллоор ойлгох шаардлагатай байна. Мөн зээлийн хүүний түвшинг харьцуулж байгаа улсуудтай зээл сунгуулах ажил ямар хугацаанд, ямар зардалтай явагддаг эсэхийг харьцуулах шаардлагатай. Ингэснээр зээлийн хүүнээс гадна бусад үзүүлэлтүүд ч гэсэн олон улсын түвшинд хүргэх боломж бүрдэнэ. Зээлийн хүү нь их өргөн хүрээг хамрах ойлголт тул стратегийн 11 зорилт хангалтгүй гэж үзэж бөгөөд дахиад хэд хэдэн асуудлыг авч үзэх хэрэгтэй. Тухайлбал, зээл төлүүлэх ажлыг хэрэгжүүлэх нь 9-р зорилтод хамрагдаж байна. Үүнийг хэрэгжүүлэх байгууллагууд нь Сангийн яам, Монголбанк гэж байна. Миний бодлоор Хууль эрх, зүйн яам, ШШГЕГ зэрэг хууль хэрэгжүүлдэг байгууллагууд оролцохгүй бол хэрэгжихэд хэцүү. Мөн стратегиудын зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээ бүрийн ард хугацааг, хэн хариуцахыг, хариуцлага хэн хүлээхийг тодорхой оруулж өгөхийг хүсье



С.Оргодол

Гүйцэтгэх захирлын орлогч
Худалдаа Хөгжлийн Банк

Миний бодлоор зах зээлийн зарчмаар зээлийн хүүг бууруулах боломжгүй гэж үзэж байна. Учир нь уг зарчмын суурь өөрөө алдаатай тул энэхүү стратеги эерэг үр дүнд хүрэх эсэхэд эргэлзээтэй байна. Стратегийн үндэслэл хэсэгт тооцоо алга, ялангуяа зээлийн эрэлт нийлүүлэлтийн асуудлыг авч үзээгүй байна. Сүүлийн 10 гаруй жил жилийн зээлийн нийт дүн 11 их наядаар нэмэгдэхэд зээлийн хүү нэмэгдээгүй байна. Эндээс зээлийн хүү мэдрэмжгүй гэдэг нь харагдаж байна. Мөн зээлийн хүүний тооцооны хувьд асуудалтай байна. Учир нь жигнэсэн дундаж аргаар тооцох нь асуудалтай. Арилжааны банкуудын зарласан зээлийн хүүний дундаж 28 хувь байна. Түүнчлэн арилжааны банкны ашгийн дээд хувь, хадгаламжийн хүүний дээд хувийг тогтоох асуудлыг авч үзэх шаардлагатай. Учир нь ойрын хугацаанд Монгол улсад зээлийн хүүг бууруулахгүй бол болохгүй байна. Оросод зээлийн дээд хязгаарыг тогтоож байна. Миний хувьд зээлийн хүүг бууруулах 2 арга байна гэж үзэж байна. Эхнийх нь зээлийн хүүгийн дээд хязгаарыг хуулиар тогтоох, нөгөөх нь Төв банк тогтоох боломжтой гэж үзэж байна.



Н.Дашзэвэг
Захирал
Монгол Дээд Сургууль,
Гавьяат эдийн засагч



А.Алтансүх
Ерөнхийлөгч
Монголын Банк Бус
Санхүүгийн
Байгууллагуудын
Холбоо

Монголбанк зээлийн хүүг бууруулах стратегийн хэлэлцүүлгийг зохион байгуулж буйд талархаж байна. Санхүүгийн секторын системийг хөгжүүлэх гэсэн зорилт нь хамгийн чухал хэсэг болов уу. Монгол улсын санхүүгийн систем олон жил нэг тулгууртай явсны үр дүнг өнөөдрийн өндөр зээлийн хүү гэж харж байна. Уг стратегийг боловсруулсан ажлын хэсэгт Санхүүгийн зохицуулах хороо, бусад санхүүгийн байгууллагуудын холбоодоос хүмүүс ороогүй харагдаж байна. Иймд стратегид Санхүүгийн зохицуулах хорооны саналыг тусгах хэрэгтэй. Манай ББСБ-ууд нэг үеэ бодвол харьцангуй чадавхжсан байна. Нийт зээлд эзлэх хувь нь 4-5 хувь хэдий ч, зээлдэгчдийн тоо нь 12-13 хувьд хүрч нэмэгдсэн байна. Бид энэ зах зээлийг, өрсөлдөөнийг нь тодорхой хэмжээнд дэмжих ёстой. Монголбанк нэг сегментийг хэт дэмжих нь хэр зөв зүйтэй бол. Мөн гаднаас татах эх үүсвэрийн татварыг бууруулах, урамшуулал олгох ажлыг ББСБ-уудад бас хамаатуулж авч үзээрэй. ББСБ-ууд гадаадын олон байгууллагуудтай харилцаж санхүүжилт татаж байгаа. Зээлийн хүү нь ч гэсэн харьцангуй бага түвшинд байдаг. Тэгэхээр олон тулгуурт санхүүгийн системийг бүхэлд нь харж, хөгжүүлээрэй гэж хүсэж байна.

Өнөөдөр Монголбанк зээлийн хүүг бууруулах стратеги чухал сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлж байгаа нь нийгэмд эерэг хүлээлтийг бий болгож байна. Төв банкны зүгээс сайн судалгаа хийгээд, уг судалгаан дээр түшиглэж зээлийн хүүг бууруулах талаар өөрийн байр суурийг илэрхийлж, хэлэлцүүлж байгаад таатай байна. Стратеги дээр ярьж хэлэх, сайжруулах зарим зүйлс байна. Зээлийн хүү бууруулах суваг инфляцитай холбогддог. Нэг талд Төв банк зээлийн хүү болон инфляцийг бууруулах талаар ажиллаж байхад, нөгөө талд Засгийн газрын нийгмийн халамжийн бодлого, ард иргэддээ мөнгө тараадаг байдал нь инфляцийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа болдог. Энэ тохиолдолд зээлийн хүүг бууруулах стратеги үр дүнгүй болох талтай. Иймд Төв банк болон Засгийн газрын харилцан уялдаатай ажиллагаа зээлийн хүүг бууруулахад хамгийн чухал нөлөөтэй. Мөн инфляцид нөлөөлж буй хүчин зүйлсийг ул суурьтай судалж, энэ дээр тулгуурлан инфляцийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авмаар санагдаж байна. Өөр нэг тулгамдаж буй асуудал бол гадаадын өр юм. Улсын төсвийн 20-25 хувьтай тэнцэх хэмжээний зээлийн төлөлт хийх байдалтай байгаа. Тийм учраас Төв банк гадаад өрийг бууруулахад Засгийн газартай хамтарч ажиллах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, тэр дундаа алтны хуримтлалыг бий болгоход онцгой анхаарах шаардлагатай.



Н.Батнасан
Дэд профессор,
Доктор (Ph.D)
Монгол Улсын Их
Сургууль



Ө.Ганзориг
Ерөнхийлөгч
Монгол Банкны Холбоо

Юуны өмнө уг хэлэлцүүлгийг зөвшилцөл, ойлголцлын уулзалт гэж харж байна. Миний бодлоор зээлийн хүү өндөр байгаа хамгийн гол шалтгаан нь төгрөгийн эрсдэл долларын эрсдэлээс өндөр байгаа явдал юм. Манай банкны холбоо долларжилтыг бууруулах талаар байнгын ажиллаж, үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Үүний үр дүнд жил хагасын өмнө байсан долларжилтын хэмжээ 45 хувиас 35 хувь хүртэл буурсан. Дахиад цаашаа бууруулъя гэхэд хүмүүсийн төгрөгт итгэхгүй байдал нөлөөлж байна. Бүгдээрээ зээлийн хүү өндөр байгаа шалтгааныг зөв тодорхойлох, оношлох шаардлагатай. Хэрвээ бид нар нэг онош дээр төвлөрч, санал нэгдэж чадвал цааш нь фокуслах, нарийвчлах шаардлагатай байна. Миний бодлоор энэ баримт бичгийн төлөвлөгөө болон стратегиуд сайн боловсруулагджээ. Гэхдээ нэг санал байгаа нь стратегийг илүү нарийвчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг илүү хурцлах нь оновчтой болов уу гэж үзэж байна. Манай банкны холбооны гүйцэтгэх захирлууд уг зээлийн хүүний асуудлаар хоёр, гурван удаа уулзаж ярилцсан. Цаашдаа Монголбанкаа дэмжээд явна. Мөн нэмж хэлэх, зайлшгүй оруулах ёстой санал бол тэтгэврийн реформ юм. Аливаа улсын хувьд тэтгэврийн реформ нь санхүүгийн систем дотроо багтдаг, төр нь үүнийг зохицуулж байдаг. Манай улс шиг арилжааны банкны хадгаламжид хийдэг тэтгэврийн системтэй улс цөөхөн. Иймд жилдээ 1.4 их наяд төгрөг цуглардаг тэтгэврийнхээ системийг реформ хийж, үүнийгээ Санхүүгийн зохицуулах хороотой хамтран хөрөнгийн зах руу оруулах хэрэгтэй.

Зээлийн хүү олон жил буурахгүй байгаа шалтгааны талаар ярилцаж байна. Миний мэдэж байгаагаар сүүлийн 10 гаруй жил банкууд зээлийн хүүг бууруулах байнгын эрмэлзэлтэй явж ирсэн. Харин төр засгийн бодлого, эрх зүй, шүүхийн тогтолцоо, төсөв, мөнгөний ямар нэг алдаатай бодлого хэрэгжиж зээлийн хүүг бууруулахаас эсрэг чиглэлд нөлөө үзүүлж ирсэн. Нөгөөтэйгүүр инфляци олон жил хоёр оронтой байсан. Үүнийг дагаад бодлогын хүү 2009 оны хямралаас хойш байнгын хоёр оронтой тоон дээр байна. Энэ нь эх үүсвэрийн өртгийг өндөр хэвээр байлгаж байна. Гэхдээ хадгаламжийн хүүг буулгах боломжтой цаг үед, харамсалтай нь банкуудын зардлуудыг нэмсэн. Тухайлбал 2009 оны хямралаас хойш эдийн засаг огцом өсөж байсан үед банкуудын эх үүсвэр нэмэгдэж, хүү буурах боломж гарах үед манай улс хадгаламжийн даатгалын тогтолцоотой болно гээд бүх банкуудаас хадгаламжийн хэмжээгээр хураамж цуглуулж эхэлсэн, одоог хүртэл үргэлжилж байна. Энэ нь хадгаламж дээр далд зардал байдлаар нэмэгдсэн. Дараагийн хүү буурах боломж бүрдэх үед хадгаламжийн хүүний орлогоос татвар авдаг болсон. Мөн шууд гардаг зардал бол заавал байлгах нөөцийн хувь юм. Өөрөөр хэлбэл сүүлийн арав гаруй жилийн заавал байлгах нөөцийн хувь буураагүй. Тэгэхээр инфляци, бодлогын хүү, заавал байлган нөөц, төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ зэрэг нь хүүг бууруулах бодлогынхоо эсрэг ирсэн байна. Эдгээрийг эхнээсээ арилгаад, бууруулаад явахад зээлийн хүү буурах боломжтой гэж харж байна. Стратегийн хувьд хүүг бууруулах асуудлыг хэт алсаас харж байна. Өдөр тутмын зээлийн хүүг нэмэгдүүлж байгаа асуудлыг шийдвэрлэхэд анхаарах хэрэгтэй. Мөн хууль эрх зүйн хувьд маш том дэмжлэг хэрэгтэй байна.



О.Орхон
Гүйцэтгэх захирал
Худалдаа Хөгжлийн Банк



О.Банзрагч
Дэд ерөнхийлөгч
Монголын Банкны
Холбоо

Банкны системийн хувьд 9 их наядын хадгаламжтай, 13 их наядын зээлийн эрэлттэй өнөөгийн нөхцөлд зээлийн хүү өндөр тогтох нь аргагүй. Учир нь Монгол улсад хуримтлал алга байна. Тэрнээс арилжааны банкууд ашгийн төлөө зээлийн хүүг өндөр тогтоодог гэж болохгүй. Арилжааны бүх банкинд зээлийн хүүг бууруулах хүсэл, сонирхол байдаг. Магадгүй банкны холбоо, арилжааны банкууд өөрсдийн үйл ажиллагааг олон нийтэд ойлгомжтой, тодорхой тайлбарлаж чаддаггүй нь алдаа дутагдал байж болох юм. Арилжааны банк өндөр ашигтай байх нь татварын сувгаар эдийн засагт эерэг нөлөөтэй гэж үзэж байна. Мөн Монголбанкны зээлийн хүүг бууруулах стратегид тусгасан зарим саналыг дэмжиж байна. Монголбанкаас одоо өгч байгаа богино хугацааны овернайт санхүүжилтийг урт хугацаатай болгох нь банкууд эх үүсвэрээ хангах боломж бүрдэх тул их зөв зүйтэй санал юм.

Энэ стратегид макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлнэ гэсэн чухал хэсэг орсон байна. Зээлийн хүүг бууруулах асуудлыг зөвхөн банкныхаа систем дотор авч үзээд, бид нар үүнийг бууруулна гэвэл учир дутагдалтай. Манай макро эдийн засгийн орчинг авч үзвэл уул уурхайн салбар дээр тулгуурласан, өрөөсгөл бүтэцтэй. Засгийн газрын хувьд эдийн засгийг төрөлжүүлэх, хөгжлийн асуудлыг шийдэх, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад бодлого тодорхойлохоос өөр хүч алга гэж харж байна. Эдийн засгийн суурь бүтцийг сайжруулахад банкны системийн оролцоо бол хөрөнгө оруулалтын чиглэлийн эх үүсвэрийг бүрдүүлэх асуудал гэж үзэж байна. Нөгөө талд хугацаатай хадгаламжийг авч үзвэл ихэнх нь 1 жил, хугацаагүй хадгаламж гэсэн богино хугацаатай эх үүсвэрээр урт хугацаат хөрөнгө оруулалт, зээлийн асуудлыг шийдэж чадахгүй нь хэн бүхэнд ойлгомжтой. Тийм учраас урт хугацаанд ажиллах эх үүсвэрийг шийдэх асуудал банкны системд тулгарчихаад байна. Стратегид төв банк хямд, урт хугацаат эх үүсвэрийг бий болгоно гэж тусгасан байна. Энэ нь өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэгдээд явах байх. Харин банкны систем өөрсдөө бүрдүүлэх урт хугацааны систем хэрэгтэй байна. Уг урт хугацааны тогтвортой эх үүсвэрийг бий болгоход Монголбанкны оролцоо бас шаардлагатай болов уу.



Д.Дуламсүрэн
Профессор,
Доктор (Ph.D)
Монгол Улсын Их
Сургууль,
Гавьяат багш

Заавал байлгах нөөцийн хувийг банкны эх үүсвэрийн төрлүүд тус бүр дээр нарийвчлан ялгаатай тогтоох боломжтой гэж харж байна. Жишээлбэл 12 сарын хугацаатай хадгаламжийн заавал байлгах нөөцийн хувийг 3 болон 6 сарын хугацаатай хадгаламжийн хувиас бага тогтоож болно. Хоёрдугаарт, зээлийн хүүг бууруулах стратегийн гол зорилго, цөм нь бизнес эрхэлж буй хүмүүс, аж ахуй нэгжүүдийг бага хүүтэй зээлээр хангах гэж үзэж байна. Иймд хэрэглээний зээлээс илүү бизнесийн зээл дээр илүү төвлөрөх, фокуслах нь зүгээр болов уу. Мөн актив, пассивын хугацааг нарийн харж үзэх шаардлагатай байна.



Л.Соронзонболд
Гүйцэтгэх захирлын
орлогч
Худалдаа Хөгжлийн
Банк



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК